



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/09

Есөнбулаг сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтай-Бургастай чиглэлийн авто замаас Алтай сумыг холбох, Алтай хотыг тойрон өнгөрч байгаа улсын чанартай авто замын зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах, гүйцэтгэлд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	М.Алтангэрэл	(Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд:	Д.Чинзориг	(Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)
	Н.Эрдэнэ-Очир	(Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)
	Б.Бямбадорж	(Аймгийн ерөнхий архитектор)
Нарийн бичгийн дарга:	З.Жаргалтуяа	(Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга (Д.Буянхишиг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

